# Нөхөр Ш. Агваансодовын тавьсан илтгэлийн төгсгөл

аймгийн АДХГ Захиргааны гишүүдийн хуралдаанаар хэлэлцүүллээ.

Эдгээр шалгалтын үр дүнд Архуст, Дэлгэрхаан сумдын ажил сайжирч 1967 оны аж ахуй, соёлын гол төлөвлөгөөт зорилтууд амжилттай биелэгдэж Дэлгэрхаан сум өнгөрсөн онд аймагт ажлаараа түрүүлсэн байна.

Аймгийн Намын Хорооны НХШК энэ 2 жилд МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 13 тогтоол, аймгийн 25 тогтоолын биелэлтийг шалгаж, шаардагдах арга хэмжээнүүдийг авахуулжээ.

Гэвч аймгийн намын байгууллагуудын хяналт шалгалтын ажилд шалгалтын мөрөөр авах арга хэмжээ хангалтгүй, гүйцэтгэлийг шалгах асуудал шаардлагын хэмжээнд хүрээгүй байна.

Иймд гүйцэтгэлийн хяналт шалгалтыг тодорхой зорилготой, дайчин шуурхай, бүтээлч, олон нийтэч шинж чанартай болгох нь чухал байна.

Тус аймгийн ҮЭ-ийн гишүүдийн 68,7 хувь нь материаллаг үйлдвэрлэл дээр ажиллаж тайлангийн хугацаанд шинэ санаачлага, тэргүүн туршлага 110-ыг үйлдвэрлэлд нэвтрүүлж 182,2 мянган төгрөгийн хэмнэлт гаргажээ.

Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс эмэгтэйчүүдийн соёлч боловсон байдлыг дээшлүүлэх, улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөг биелүүлэхэд тодорхой зорилттой ажиллаж байна.

Аймаг сумдын АД Хурлуудын чуулган нь тогтмолжин чуулганд байнгын комиссын тайлан ба хавсралт илтгэлийг оруулан хэлэлцүүлдэг боллоо.

Олон нийтийн байгууллагуудаас ч жинхэнэ материаллаг үйлдвэрлэл дээр олон түмний дунд ажилладаг тасаг, бригад, цехийн дэргэдэх ХЗЭ-ийн үүр, хэсэг, үйлдвэрчний бүлэг, эмэгтэйчүүдийн салбар зөвлөл, МЗНН-ийн зөвлөл, депутатын хэсгийн ажлыг тогтмолжуулах, зааварлах, туслах ажил бараг хийгдэхгүй байна.

Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын зохион байгуулалт, соёл хүмүүжлийн ажлыг улам идэвхжүүлж, үйлдвэрлэлийг удирдах ба төлөвлөх ажилд оролцох ролийг нь дээшлүүлж үйлдвэрлэл үйлчилгээнд тавих үйлдвэрчний эвлэлийн хяналтыг улам хүчтэй болгох хэрэгтэй байна.

Төрийн захиргааны, олон нийтийн байгууллага, депутат, байнгын комиссын ажлыг төрийн ардчиллыг бэхжүүлэх,захиргааны дотоод ажлыг сайжруулах, хууль дүрмийн биелэлтэнд тавих хяналтыг хүчтэй болгоход чиглүүлж явуулах хэрэгтэй.

Олон нийтийн байгууллагуудын ажлыг жигд тогтмолжуулан сайжруулахад аймгийн намын 3 дугаар бүгд хурлын шийдвэрийг үндсэн удирдлага болгож ажиллавал зохино.

Хуулийн байгууллагууд бусад улс, олон нийтийн байгууллагуудтай хамтарч ажиллах явдал хангалтгүй, өмч хөрөнгө идэж ашигласан тухай мэдээ сэлтийг хүлээж суудаг буруу практик байсаар байна.

Аймгийн прокурор, цагдан сэргийлэх байгууллагууд хөдөлмөрийн сахилга зөрчигчид, ажлын хариуцлага алдагчидтай тэмцэх явдал сул байна.

Шүүн таслах хурлын хүмүүжүүлэх нөлөө,хуулийн биелэлтэд тавих прокурорын ерөнхий хяналт шаардлагын хэмжээнд хүрч чадахгүй байна.

Шүүн таслах хурлын хүмүүжүүлэх нөлөөг сүрхий дээшлүүлж, прокурорын ерөнхий хяналтын ажлын голыг өмч хөрөнгийг хамгаалах, хүмүүсийн ажлын хариуцлага сахилга бат, нийгмийн хэв журмыг сахиж журамлахад чиглүүлбэл зохино. Тайлангийн хугацаанд аймгийн Намын Хороо боловсон хүчнийг шилж сонгож, хувиарлах тэднийг ажил дээр нь сургаж хүмүүжүүлэх талаар мэргэжлийн сэхээтнүүдтэй хэрхэн ажиллаж байгаа тухай аймгийн Гэгээрлийн хэлтсийн дарга, боловсон хүчнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар Гачууртын САА-н дарга н.Пүрэвдоржийн илтгэлүүдийг авч хэлэлцжээ.

Удирдах ба мэргэжлийн боловсон хүчнүүдийн эрхэлсэн ажлын мэдлэг дадлага, ажлын арга барилыг нь дээшлүүлэх зорилгоор туршлага солилцох сургууль,семинар зөвлөлгөөн хийж, намын анхан шатны хороо, үүрийн нарийн бичгийн дарга, сум-САА-н дарга, аймгийн нам, улс,олон нийт, үйлдвэр аж ахуйн дарга, зарим мэргэжилтнүүдийг оролцуулсан тэргүүн туршлагын сургуулийг явуулсан нь сайн нөлөө үзүүллээ.

Гэвч намын байгууллагуудаас боловсон хүчнийг зөв судлан байршуулж, тэднийг ажилд нь сургаж хүмүүжүүлэх талаар жигд тодорхой ажиллахгүй байна. Боловсон хүчнүүдэд тавих зарчимч шаардлага халамж анхаарлыг ямагт өндөр байлгаж тэднээс биеэ дааж эрхэлсэн ажлынхаа хувь заяаг хариуцах хариуцлагыг өндөржүүлэх хэрэгтэй. Аж ахуй, соёлын байгуулалтыг удирдах шилдэг арга болсон тэргүүн туршлагыг нэгтгэн нэвтрүүлэх, туршлага судлах сургууль байгуулах, социалист уралдаан өрнүүлэх ажлыг намын байгууллагуудын гол ажил болговол зохино.

Судлах, сурталчлах, зохион байгуулах ажил бол намын ажлын гол арга мөнийг ямагт удирдлага болгож намын байгууллагын удирдлагын дайчин чадварыг өндөржүүлэх хэрэгтэй байна.

Аймгийн намын XIV бага хурлыг угтаж манай аймгийн нам, улс, олон нийт, үйлдвэр аж ахуй, соёлын бүх байгууллагууд 30-45 хоногийн цогцтой ажлын төлөвлөгөө зохиож 1968 оны аж ахуй,соёлыг хөгжүүлэх төлөвлөгөөний эхний хагас жилийн ажлыг 5 хоногийн өмнө ханган биелүүлэх хөдөлгөөнийг аймаг даяар өрнүүлж гялалзсан амжилтууд гаргалаа.

НӨХӨД ӨӨ!

Саяхан Аймгийн Намын Хорооны тайланг намын анхан шатны байгууллагуудын бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлж бүх гишүүдийн 90,8 хувь нь оролцож 300 гаруй гишүүд санал шүүмжлэл гаргаж Аймгийн Намын Хорооноос тайлангийн хугацаанд авч явуулсан арга хэмжээг зөв зүйтэй гэж үзжээ.

Намын Хорооны тайланг хэлэлцсэн намын гишүүдийн санал шүүмжлэлд дүгнэлт хийж үзэхэд: Намын байгууллагуудаас боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах,эмэгтэйчүүдийг удирдах ажилд дэвшүүлэх, олон нийтийн байгууллагуудын бие даасан ажиллагаа ялангуяа залуу үеийг хүмүүжүүлэх ажил, намын ухуулгын ажлын далайц үр нөлөө хангалтгүй, эмнэлэг үйлчилгээний газруудын ажил шаардлагаас хоцорч байгааг онцлон шүүмжилжээ.

Тэрчлэн малын хариулага маллагаа, малчдын хариуцлага жигд сайжраагүй, дотоод нөөц боломжоог бүрэн ашиглах явдал муу байгааг намын олон гишүүд баримтаар шүүмжилжээ.

Намын гишүүдийн энэ шүүмжлэл нь намын байгууллагуудын зохион байгуулалт, үзэл суртлын ажлын нэгдлийг бүх талаар хангаж, намын анхан шатны байгууллагуудаас улс, олон нийт, үйлдвэр аж ахуй, соёлын байгууллагуудын ажлыг удирдах удирдлагыг эрс дээшлүүлэхийг зүй ёсоор шаардаж байна.

МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөл «Зудтай тэмцэж хор уршгийг арилгах зарим арга хэмжээний тухай», «Малыг зудаас хамгаалж онд сайн оруулах талаар тавих зорилтын тухай» чухал шийдвэрийг гаргалаа.

Эдгээр удирдамжуудыг биелүүлэхэд аймгийн нам, улс, олон нийт, аж ахуйн бүх байгууллага, нийт хөдөлмөрчдийн хүчийг зөв хувиарлаж бүх нийг мал аж ахуйн материаллаг баазыг хангуулахад чиглүүлэх хэрэгтэй.

1968 оны сүүлийн хагас жилд бидний өмнө асар хариуцлагатай зорилтууд тулгарч байна.

Энэ зорилтыг биелүүлэхийн тулд ойрын үед бүх нийтээр хадланд жигдрэн гарч аймгийн хэмжээгээр 110 мянган тонн хадланг 9 дүгээр сарын 1-ний дотор авч хамгаалсан байх.

1968 оны улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтын дутууг үзүүлэлт бүр дээр нь ханган биелүүлэх гол ажлуудад бүх хүчийг чиглүүлэн ажиллах шаардлагатай байна.

Улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 4 дүгээр 5 жилийн төлөвлөгөөний зорилтоос үндэслэж үлдэж байгаа хоёр оны бүх ажлыг МАХН, ардын хувьсгалын 50 жилийн ой, Лениний мэндэлсний 100 жилийн ойг угтаж бүрэн биелүүлэхийг аймгийн нам, улс, олон нийт аж ахуй,соёлын бүх байгууллага, нийт хөдөлмөрчид, намын бүх гишүүд, орлогчдоос уриалж байна.

# Аймгийн Намын 14 дүгээр бага хуралд Шалган Байцаах Комиссын дарга Д.Сундуйн тавьсан тайлан илтгэлээс

Намын Хорооны шалган байцаах комисс тайлангийн хугацаанд Намын Төв Хорооны тусгай тасаг санхүүгийн хэлтсүүдээс аймгийн Намын Хорооны бичиг хэргийн хөтлөлт, санхүүгийн байдлыг шалгаж зааварласан нь намын анхан шатны үүр, хороодын дотоод ажлыг сайжруулахад чухал ач холбогдолтой болсон юм.

Шалган байцаах комиссоос дээрх хэлтэс,тасгуудтай хамтран шалгалтанд оролцсоноос гадна төв хөдөөгийн 20 үүр, хороод дээр шалгалт явуулж акт зааварчлага бичсэн ба Намын Хорооны барилгын өргөтгөлийн эцсийн үр дүн, аж ахуйн тасгийн эрхлэгч байсан н. Равжирын тооцоог бодсон зэрэг цаг үеийн шаардлагатай ажлуудад оролцож холбогдох арга хэмжээнүүдийг авахуулж байлаа.

Аймгийн Намын Хороо тайлангийн хугацаанд намын мөнгөн хөрөнгийг арвижуулах, төсөвт зардлуудыг хэмнэж зөв зарцуулах, тайлан тооцооны ажлыг сайжруулахад анхаарч ирсэний дүнд Намын Хорооны санхүүжилтийн байдал зөв явагдаж ирлээ.

Намын байгууллагуудын мөнгөн хөрөнгийн үндсэн эх үүсвэр нь намын гишүүдийн татвар юм. Аймгийн Намын Хороо намын гишүүдийн татварын орлогын төлөвлөгөөг 1966 онд 100,2 хувь, 1967 онд 103,6 хувиар тус тус биелүүлсэн ба намын үүр хороод татварыг 10 хоногийн дотор аймгийн Намын Хорооны санхүүд тушаадаг заншилтай болжээ.

Гэвч намын гишүүдийн татвар хураалтын ажлыг намын үүр, хороодын нарийн бичгийн дарга нар өөрснөө гардан хариуцах ёстойг Баяндэлгэр, Эрдэнэ, Угтаал сумдын Намын Хороо үүрийн нарийн бичгийн дарга нар одоо болтол зөрчиж байна.

Эдгээр сумдад гишүүдийн татвар хураалтын байдал хангалтгүй, гишүүд нэг бүртэй нэмэгдэл хөлсний тооцоо хийгээгүй байлаа.

Зарим намын гишүүд онцлох шалтгаангүйгээр татвараа 2-3 сараар хураалгаагүй байхад дээрх намын үүрүүдээс авсан тодорхой арга хэмжээгүй байна.

Энэ мэтээр татварын зааврыг зөрчиж гишүүд нэг бүртэй нарийн тооцоолж сардаа багтааж татвараа хураалгадаг зарчмыг хатуу мөрдүүлэх талаар дутагдалтай ажиллаж байгаа хороод цөөнгүй байна.

Намын гишүүдийн татвар хураалт, тушаалтын ажил ийм байдалтай байгаа нь намын дүрмийн шаардлагыг намын зарим үүр, хороод гишүүдээс муу биелүүлж, гишүүдийн манлайлал жигд сайжирч чадаагүй байгаагаас шалтгаалж байна.

Намын гишүүдийн татвар хураалтын ажилд дээрх дутагдлууд үргэлжилсээр байхад аймгийн Намын Хорооны шалган байцаах комисс хүртээмжтэй ажиллаж шалгалт хийж чадаагүй, татварын орлогын талаар зөрчил гаргагчид дээр авах арга хэмжээ хангалтгүй байв.

Гишүүний татварыг үндсэн цалин дээр түүний нэмэгдэл орлогыг нэмж бодсоноор хураавал зохих байтал ихэнх үүр, хороод энэ зааврыг биелүүлэхгүй байгааг анхаарах нь зүйтэй.

Онцлох шалтгаангүйгээр намын гишүүний татварыг сард нь хураалгаагүй буюу орлогоносоо дутуу хураалгасан гишүүдэд намын дүрмийн дагуу арга хэмжээ авч намын сахилга алдагчидтай намын анхан шатны байгууллага бүр ажиллаж байвал зохино.

Гишүүдийн татвар хураалтын байдлыг намын үүр, хороод тус бүр дээр улирал дутам шалган үзэж дүнг Намын Хорооны товчоо, дарга нарын зөвлөлгөөн, намын үүр, хороодын гишүүдийн хуралд оруулан хэлэлцүүлж байх нь чухал байна.

Тайлангийн хугацаанд Намын Хорооны аж ахуй, санхүү тайлан бүртгэлийн ажиллагаа зөв явагдаж орлого хуримтлал ба төсөвт зардлыг цаг хугацаанд нь санхүүжүүлж ирсэн гэж аймгийн

*(Үргэлжлэл нь 5 дугаар нүүрт)*

# Аймгийн Намын 14 дүгээр бага хуралд Шалган Байцаах Комиссын дарга Д.Сундуйн тавьсан тайлан илтгэлийн төгсгөл

гийн Намын Хорооны шалган байцаах комисс үзэж байна.

Аймгийн Намын Хорооны аж ахуй санхүү хариуцсан хүмүүс тайлан бүртгэлийн ажлыг сайжруулан аж ахуйч ажиллагааг дээшлүүлсний дүнд төсөвт зардлыг нэр төрөл бүр дээр нь хэмнэж чадсан юм.

Гэвч батлагдсан төсвийг жил улиралд багтааж төлөвлөсөн зүйлд хяналт сайтай бүрэн гүйцэт зарцуулах явдал хангалтгүй байна.

Мөн жинхэнэ аж ахуйч ажиллагаанаас буюу дотоодын нөөц бололцоог ашигласнаас орох арвилан хэмнэлтийг урьдчилан зөв сайн тооцоолж ажилтан нэг бүрийг төсөвт зардал хэмнэхэд чиглүүлж чадаагүй байна

Эд аж ахуй, мөнгөн касс хариуцсан хүмүүсийн ажлын хариуцлагагүйгээс шалтгаалж бүрдэл болоогүй баримтаар хөрөнгө зарцуулах буюу кассын гүйлгээ хийх явдал нярав байсан Сономцэрэн, аж ахуйн тасгийн дарга байсан н. Равжир нар дээр үзэгдэж байв.

Цаашид аж-ахуй, санхүү бүртгэл тооцооны ажилд тэргүүний дэвшилт арга ажиллагааг нэвтрүүлэн арвилан хэмнэлт гаргаж ажилласан аж ахуйч ажиллагаатай ажилтнуудыг, оруулсан хэмнэлтийн үр дүнгээр урамшуулан шагнаж байвал зохино.

Аймгийн Намын Хорооны шалган байцаах комиссын гүйцэтгэх үүргийн гол нь аймгийн Намын Хороонд орж гарч буй бичиг хэргийн эмх цэгц уг асуудлыг хир зэрэг шуурхай шийдвэрлэж байгааг шалгаж хянах явдал юм.

Аймгийн Намын Хороонд орж гарч байгаа хэргүүдийн ихэнхийг намын гишүүд орлогчдын элсэлт арга хэмжээний материалууд эзлэж байна. Аймгийн Намын Хороо, намын гишүүд орлогчдын элсэлт арга хэмжээний асуудлыг тайлангийн хугацаанд урьд онуудаас улам шуурхай болгож чадсан байна.

Намын гишүүд, орлогчдын асуудлыг хөнгөн шуурхай шийдвэрлэж намын эгнээг тэргүүний хүмүүсээр бэхжүүлэх талаар Их хайрхан, Жаргалант, Мөнгөнморьтын намын хороо, үүрүүд бусдаасаа илүү сайн ажиллаж байна.

Гэвч зарим анхан шатны намын хороо, үүр, гишүүд, орлогчдын материалыг хагас дутуу бүрдүүлэх,батлан даалт нь цохолтгүй, батлан даагчдын гарын үсэг, батлахын дугааргүй байх юмуу эсвэл ажил төрлийн тодорхойлолтгүй, тогтоолд гарын үсэг, тамга, тэмдэггүй байснаас хойшлогдож байжээ.

Мөн намын үүр, хороодын бичиг хэрэг, тоо бүртгэлийн эмх цэгц олигтой сайжирч чадаагүй, шилжиж ирэх ба явагчид олон цөөн хоногоор завсардах явдал ч гарчээ.

Намын батлах олгох ба хадгалах журмыг хатуу сахиж энэ талаар намын байгууллагын удирдах хүмүүс гишүүд, орлогчдын хариуцлага, сонор сэрэмжийг дээшлүүлэх нь чухал.

Аймгийн Намын Хорооны хэлтэс тасгуудаас МАХН-ын Төв Хороонд явуулдаг мэдээнүүд нь тогтмолжиж, дотоод бичиг хэргүүдийн эмх цэгц нь эрс сайжирсан байна.

Аймгийн Намын Хороо аппаратынхаа бичиг хэргийг эмх цэгцтэй шуурхай болгох талаар нилээд ажил зохиосны үр дүнд бичиг хэрэг нь архивын заавар дүрмийн дагуу зөв хөтлөгдөж хугацаандаа шийдвэрлэгдэж байна.

Гэвч бичиг хэргийн шинэ зааврыг мөрдлөг болгох талаар аймгийн Намын Хорооноос намын үүр, хороодын нарийн бичгийн дарга нарт тодорхой семинар зөвлөлгөөн өгч уг зааврыг хүргүүлсээр байтал Баянзүрх, Эрдэнэ сумдын намын үүр хороодоос энэ талаар хийсэн зүйлгүй байна.

Мэдээ, мэдээллийн ажил нь нам, ард түмний холбоог бэхжүүлж аливаа нэгэн ажилд саад болж байгаа ажлын дутагдлыг арилгахад манай намд байнга туслаж байдаг чухал хүчин зүйл юм.

Хэдий тийм боловч ирж буй мэдээллийн гол нь ажлын хоцрогдол, дутагдал, салан задгай байдлыг шүүмжлэх хэлбэрээр гарч байжээ.

Харин ажлын ололт, амжилт, тэргүүний хүмүүсийн ажлын туршлагыг тун бага мэдээлж байна. Цаашид Намын Хороонд орж гарч байгаа бичиг хэргүүдийг улам эмх цэгцтэй шуурхай болгон архивын заавар дагуу хөтлөж хөдөлгөөн бүрийг зөв хөтлөж байх.

Ялангуяа мэдээ, мэдээллийн мөрөөр шалгах шалгалтыг онцгой сайжруулан хугацаанд нь шийдвэрлэж байх нь чухал байна.

НӨХӨД ӨӨ!

Аймгийн Намын Хорооны мөнгөн хөрөнгө, бүртгэл санхүү, дотоод ажил нь тайлангийн хугацаанд зөв явагдаж ирсэн гэдгийг шалган байцаах комиссоос аймгийн намын XIV бага хуралд тайлагнан тэмдэглэж байна.

# Намын бага хурлын индрээс

Аймгийн намын ээлжит XIV бага хурал өчигдөр нээгдэж аймгийн Намын Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ш. Агваансодовын тавьсан «Аймгийн Намын Хорооны тайлан», мөн Шалган байцаах комиссын дарга Д.Сундуйн тавьсан «Шалган байцаах комиссын тайлан» илтгэлүүдийг тус тус хэлэлцлээ.

Илтгэлүүдтэй холбогдуулан Баянцогт сумын намын байгууллагын төлөөлөгч Я.ЦЭРЭНДОРЖ үг хэлэв.

н. Цэрэндорж хэлэхдээ: Тус сумын намын гишүүд, орлогчид аж ахуй, соёлын салбарт олон түмнийг үлгэрлэн манлайлж намын гишүүнийхээ үүргийг нэр төртэй биелүүлж байна.

Газар тариаланд ажиллаж байгаа намын гишүүдийн 90,9 хувь нь 1967-68 оны төлөвлөгөөт ажлуудыг 102,1-180 хувиар биелүүлж малчин ба бусад ажилчин гишүүд, орлогчид үйлдвэрлэлийн нормоо амжилттай биелүүллээ.

Тайлангийн хугацаанд сумын нийт малын тоо 10336 толгойгоор нэмэгдэж мал өсгөх улсын төлөвлөгөөг 1966, .67 онд 106,2-109,8 хувиар биелүүлсэн ба тариалангийн талбай 3,2 хувиар нэмэгдэж тариалах төлөвлөгөөг 100,6-102,7 хувиар биелүүлэв.

Түүнчлэн бэлтгэлийн үндсэн нэр төрлийн зүйлүүд 100-133,4 хувиар биелэгдэж, соёл үйлчилгээний төлөвлөгөөт зорилтууд амжилттай биелэгдэв.

Аймгийн намын XIV бага хурлыг угтсан өдрүүдэд ч манай бүтээлч хөдөлмөрчид ихээхэн амжилт оллоо.

Энэ жилийн тариалалтын төлөвлөгөөг 5 дугаар сарын 15-нд 102,7 хувиар, уринш хагалах төлөвлөгөөг хугацаанаас нь 15 хоногийн өмнө 100,3 хувиар биелүүлж 9900 га-гийн уринш бэлтгээд боловсруулалтыг хийж байна гэв.

Дараа нь Бүрэн сумын намын байгууллагын төлөөлөгч Т.ШИРЧИН үг хэлэв.

н. Ширчин хэлэхдээ: 1967-68 онд болсон ган зуд бол манай улсын 13 аймаг, 159 сум өөрөөр хэлбэл бүх нутгийн дөрөвний гурван хувийг эзлэж урт хугацаатай аюул хөнөөлтэй зуд болсон юм.

Иймээс энэ ган зудын хор хохирлын тухай Ардын Их Хурлын ээлжит чуулганаар оруулан хэлэлцэж ойрын жилд зудын хохирлыг нөхөж цаашид мал сүргээ хэвийн хэмжээгээр өсгөх зорилт дэвшүүлэн тавьсан билээ.

Энэ зорилтыг ханган биелүүлэхэд олон арга хэмжээ байгаагийн дотроос хамгийн гол нь мал сүрэгт дээд зэргийн тарга хүч авахуулах явдал хамгийн чухал асуудал мөн гээд малд дээд зэргийн тарга хүч авахуулах, малыг үргэлжийн хариулага маллагаатай байлгах, хашаа байраар бүрэн хангах тухай дэлгэрэнгүй ярив.

Жаргалант сум САА-н намын байгууллагын төлөөлөгч, БНМАУ--ын Хөдөлмөрийн баатар Д.АРЪЯА үг хэлэв.

Д. Аръяа хэлэхдээ: Аймгийн намын XIII бага хурлын шийдвэрийг Жаргалант сумын намын байгууллагууд удирдлага болгон ажиллаж намын зохион байгуулалт, үзэл суртлын бүх ажилд нилээд амжилтуудыг оллоо.

Тайлангийн хугацаанд жил бүр 10 гаруй тэргүүний хүмүүс МАХН-д элсч одоо манай сум 160 гаруй коммунистуудтай боллоо.

Манай сум, САА-д намын эгнээ зөвхөн тооны талаар өсөөд зогсоогүй намын гишүүдийн бүрэлдэхүүнд чанарын ихээхэн өөрчлөлт гарлаа.

Намд элсэгчдийн 60 гаруй хувь нь малчин комбайн тракторын жолооч зэрэг материал баялгийг үйлдвэрлэн бүтээгчид юм гээд өөрийн САА-н намын байгууллагаас зохиож байгаа ажлын туршлагаас дэлгэрэнгүй ярьсаныхаа дараа залуучуудын улс төрийн сургуулийн зохион байгуулалт, хөдөлмөр соёлын чуулганыг явуулах хугацаанд зарим өөрчлөлт оруулах, олон тооны хүмүүсийг аймгийн төвөөс сумдад төлөөлөгчөөр явуулах, сумаас төвд дуудах явдлыг хорогдуулах, аймаг сумын төвийн үйлдвэрлэлийн бус хүрээнд орон тоог дахин хянаж үзэх хоёр дахь том ажлыг ойрын үед зохиох, мөн өөрсдийн нөөц бололцоог илрүүлэн ашиглаж зудын улмаас гарсан хор хохирлыг арилгахад хувь нэмрээ оруулах зорилгоор, болсон гурил будаа үйлдвэрлэх ажлыг бололцоотой нэгдэл, САА-д зохиох нь чухал байна гэлээ.

Дараа нь Дэлгэрхаан сумын намын байгууллагын төлөөлөгч Л. БАНЗРАГЧ үг хэлэв

н. Банзрагч өөрийн сум-нэгдлийнхний ажлын амжилтаас дэлгэрэнгүй яриад хүн нэг бүртэй ажиллах, хүнийг хүмүүжүүлэх, хүн бүрийн ажил хариуцах хариуцлагыг өндөржүүлэх, боловсон хүчнийг зөв сонгож тэднийг үр дүн гаргаж чадах ажилд зөв хувиарлах, ялангуяа шинээр сургууль төгссөн залуу боловсон хүчин мэргэжилтнүүдтэй уйгагүй ажиллах, үзэл суртлын ажилчдын төрөлжсөн зөвлөлгөөнийг сайн бэлтгэлтэй гээр жилд нэг удаа хийлгэж байхаар санал тавив.

Баянжаргалан сумын намын байгууллагын төлөөлөгч НЯМДАВАА хэлэхдээ: МАХН, засгаас ХАА-н нэгдлүүдийг аж ахуй, зохион байгуулалтын талаар бэхжүүлэхийн тулд байнга анхаарч байдгийн үр дүнд манай ХАА-н байгууллагууд хэлбэрэлтгүй бэхжиж гишүүдийн аж амьдрал сайжирсаныг бахархан тэмдэглээд сум, суурь өөрийн ажлынхаа тухай ярив.

Тэрээр цааш хэлэхдээ: Манай суурь сүүлийн 5 жилд нийтдээ 3858 хонь, ямаа төллүүлж 3951 толгой төл бойжуулж нэгдэлдээ хүлээлгэн өгсөн юм.

Би МАХН-ын гишүүний хувьд аймгийн намын XIV бага хурлыг угтаж энэ онд 714 хонь ямаанаас 722 хурга,ишиг бойжуулж нийгмийн 84 ямаа самнаж ямаа нэг бүрээс нь 300 грамм ноолуур ашиглах үйлдвэрийн даалгаврыг 315 граммаар буюу нэг ямаанаас 15 грамм ноолуур илүү ашиглав.

Би төл бойжуулах, ямааны ноос, ноолуур авч ашиглаж байгаа ажлын энэ өчүүхэн ахицанд өөрөө дүгнэлт хийхдээ хонь ямааг хавар намар зуны улиралд отроор таргалуулах ажил зохиож намар 11 сараас, авсан тарга хүчийг тогтоож чадсанд хамаг хэргийн гол байна гэж үздэг гэв.

Баян сумын намын байгууллагын төлөөлөгч, багш НОРЖМОО үг хэлэв.

Тэрээр Би ардын боловсролын ажилд 21 дэх жилдээ ажиллаж сүүлийн 5-6 жилд нь хариуцсан ангиа 100 хувь сургаж байна гээд сургуулийнхаа болон өөрийн ажлынхаа туршлагаас яриад цааш нь одоо манай хамт олон ардын боловсролын Яам, соёл гэгээрлийн ажилчдын ҮЭ-ийн Төв Хорооны хамтарсан уралдааны болзлыг хангаж, ардын хувьсгалын 50 жилийн ой Лениний мэндэлсний 100 жилийн ойгоор улсын тэргүүний соёлч сургууль болохоор үүрэг аваад амжилттай ажиллаж байна гэв.

Намын бага хурлын төлөөлөгч, аймгийн ҮЭ-ийн Зөвлөлийн дарга Д. ЛУВСАНДОРЖ үг хэлэв. н. Лувсандорж аймгийн Намын Хорооноос явуулж ирсэн практик үйл ажиллагааг сайшааж, намын байгууллагаас аж үйлдвэр, ХАА-н үйлдвэрлэл болон нам бус олон нийтийн байгууллагуудын ажлыг удирдах арга барилыг сайжруулахыг онцлон тэмдэглээд зарим үйлдвэрийн газар үйлдвэрлэлийн программыг биелүүлснээр санаа тайвширч аж ахуй, соёлынхоо байгуулалтыг алсаас харсан судалгаа, эдийн засгийн тооцоонд тулгуурлаж үйлдвэрийнхээ ашигт ажиллагааг дээшлүүлэхэд төдий л анхаарахгүй байна.

Энэ бол манай үйлдвэр аж ахуйн захиргаа

*(Төгсгөл нь 6 дугаар нүүрт)*

Орон бүхний пролетари нар нэгдэгтүн

# Анхдугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо, А.Д.Х. Гүйцэтгэх захиргааны сонин.

21 дэх жилдээ
№ 50 (1739)

1968 ОНЫ
7 ДУГААР САРЫН 5

БААСАН

### *Аймгийн намын 14 дүгээр бага хуралд. ирүүлсэн рапорт*

Аймгийн намын 14 дүгээр бага хурлыг угтаж Гачуурт сум-сангийн аж ахуйн хамт олон бид 1968 оны эхний хагас жилийн төлөвлөгөөт зорилтуудыг 5 хоногийн өмнө давуулан биелүүлэхийн тулд өндөр бүтээлийн сарын ажил зохиож, төлөвлөгөөт зорилтууд амжилттай биелэгдлээ. Малын хашаа шинээр 3-ыг барьж, 7 хашаанд засвар хийлээ.

Мөн мал бэлтгэл, хонины уртын ноос, тэмээний ноос,ямааны ноолуур, хялгас,бодын хялгас, хөөврийн төлөвлөгөөг 108,6-126 хувиар биелүүлэв. Улсад тушаах эхний хагас жилийн сүүний төлөвлөгөө 107,5 хувиар биелэгдэв.

Манай сум-САА 1968 онд мал өсгөх улсын төлөвлөгөөг 102 хувь, улсад тушаах сүүний төлөвлөгөөг 104 хувиар биелүүлж, 100 мянган литр сүү нэмж тушаах, малын тэжээл бэлтгэх төлөвлөгөөг 101 хувиар тус тус биелүүлнэ гэдгээ илэрхийлж байна.

**Гачуурт сум-сангийн аж ахуйн хамт олон**
1968—7—4.

# Аймгийн намын 14 дүгээр бага хуралд Намын Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга нөхөр Ш.Агваансодовын тавьсан тайлан илтгэлээс

НӨХӨД ТӨЛӨӨЛӨГЧИД ӨӨ!

Аймгийн намын 13 дугаар бага хурлаас хойш 2 жил илүү боллоо. Энэ хугацаа нь хүн төрөлхтний түүхэнд шинэ шинэ үйл явдлуудаар дүүрэн үе байлаа.

Нийгмийн хөгжлийн үндсэн хандлага-ертөнц дахиныг хувьсган өөрчлөгч коммунист хөдөлгөөний өрнөлт, социалист хүчний өсөлтөөр тодорхойлогдож олон улсын ажилчин анги,бүх хөдөлмөрчдийн эв санааны нэгдэл улам бэхжиж байна.

Социалист системийн орнуудын эдийн засаг, капиталист орнуудынхаас эрс хурдан өсөж, эдийн засаг, соёлын хөгжил, ард түмний аж амьдралыг сайжруулах үйлсдээ их амжилт олж социализмын давуу тал, коммунизмын үзэл санааны аугаа их хүчийг илтгэн харуулж империализмын түрэмгийллийг хазаарлах бодит хүчин болсон байна.

Олон улсын ажилчин анги нь хүн нийгмийн аугаа их хүчин болж, монополистуудын эсрэг хөдөлмөрлөх эрх, улс түмний найрамдал, эв санааны нэгдлийг бэхжүүлэх энх тайван ардчиллын төлөө тэмцлийг өрнүүлж байна.

Олон улсын коммунист хөдөлгөөн, орчин үед хамгийн шийдвэрлэх нөлөөтэй улс төрийн хүч, нийгмийн дэвшлийн хамгийн чухал хүчин зүйл болсныг коммунист ажилчны намуудын Будапештын зөвлөлдөх уулзалт харуулж улмаар коммунист ажилчны намуудын олон улсын зөвлөлгөөн хийхэд чухал практик алхам хийв.

Энэ оны 11 дүгээр сард Москвад болох олон улсын коммунист, ажилчны намуудын зөвлөлгөөн нь коммунист хөдөлгөөний нэгдлийг бэхжүүлж империализмын эсрэг ард түмний үндэсний болон дэлхий дахины энх амгалан байдлын төлөө тэмцэж байгаа бүх хүчний нэгдэл нягтралд үлэмжийн их хувь нэмэр болох нь эргэлзээгүй юм.

ЗХУКН болон ах дүү коммунист намууд,түүний дотор МАХН коммунист хөдөлгөөний эв нэгдлийг Марксизм-Ленинизм,пролетарийн интернационализмын зарчимч байр суурин дээр бататган бэхжүүлэхийн төлөө ихээхэн хүч чармайлт тавьж байгаа юм.

Өнгөрч байгаа 2 жил илүүгийн дотор манай орны нийт хөдөлмөрчид МАХН-ын зөв мэргэн удирдлагын дор улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 4 дүгээр 5 жилийн төлөвлөгөөг амжилттай биелүүлэх тэмцэлдээ гялалзсан сайхан амжилтуудыг олж ирлээ.

Хэдийгээр 1967-68 оны өвөл цагт манай орны ихэнх нутагт зудын бэрхшээл тохиолдсон боловч нам, засгаас авч явуулсан олон талт арга хэмжээ ба агуу их хань Зөвлөлт Холбоот Улсаас үзүүлсэн өгөөмөр тусламж, дотоод нөөц боломцоогоо илрүүлэн ашиглах үндсэн дээр зудаас учирсан хор уршгийг арилгахад манай орны нийт хөдөлмөрчдийн улс төр хөдөлмөрийн идэвхийг улам оргилуулан зоригжуулж байна.

**НЭГ. Аймгийн аж ахуй, соёлыг хөгжүүлэх 4 дүгээр таван жилийн төлөвлөгөөний эхний 2 жил хагасын төлөвлөгөөний биелэлт, цаашид тавих зорилт**

Тайлангийн хугацаанд аймгийн намын байгууллагуудаас зохиосон улс төр, зохион байгуулалтын ажил нь МАХН-ын 15 дугаар их хурлын шийдвэр, түүнээс баталсан намын программ, МАХН-ын Төв Хорооны удирдамжийг хэрэгжүүлэх, аймгийн улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 4 дүгээр 5 жилийн төлөвлөгөөний эхний 2 жил хагасын төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхэд чиглэгдэж ирлээ. Улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 4 дүгээр таван жилийн төлөвлөгөөний эхний 2 жил хагасын хугацаанд тус аймгийн ХАА-н үйлдвэрлэл багагүй ахиц оллоо.

Аймгийн дүнгээр 1967 онд өнгөрсөн оныхоо малыг 1,7 хувиар буюу 22,1 мянган толгойгоор өсгөж, урьд оноос 95300 төлийг илүү бойжуулан, малын зүй бусын хорогдлыг 33,2 хувиар багасгажээ.



1966-67 онуудад малын саравчтай хашаа 536-г шинээр барьж 35 өрөмдмөл, 177 уурхайн худаг шинээр гаргасан нь урьдах жилүүдийн гүйцэтгэлээс давжээ.

Малд саравчтай хашаа барих талаар Мөнгөнморьт, Баянзүрх, Бүрэн, Сэргэлэн зэрэг сумад бусдаасаа илүү ажиллав.

Гэвч тус аймагт мал аж ахуйг өсгөн хөгжүүлэх өргөн их боломцоог ашиглаж чадахгүй байгааг хэлэх хэрэгтэй.

1966-67 онуудад аймгийн хэмжээгээр 218 мянган малыг зүй бусын шалтгаанаар хорогдуулан, 136 мянган төлийг арчилгаа маллагааны муугаас үхүүлсэн байна.

Үүнээс гадна малын сувайралт, хээл хаях явдал эрс багасч чадаагүй байна.

Малын хорогдлыг багасгаж, төлийг бүрэн бойжуулахад цаг агаарын хувьд зохимжтой жил болсон 1967 онд Мөнгөнморьт, Баяндэлгэр, Баянзүрх, Эрдэнэ, Лүн зэрэг сумд 1966 онд байсан малаа ихээр хорогдуулсан байна.

Мал хорогдож байгаа үндсэн шалтгаан бол малын тарга хүч муу, малыг хашаа саравч, худаг ус, хадлан тэжээлээр бүрэн хангаж чадахгүй байгаад оршино.

1967 онд аймгийн хэмжээгээр саравчтай хашаа барих төлөвлөгөөг 63,5 хувиар, худаг ус гаргах төлөвлөгөөг 37,1 хувиар, хадлан бэлтгэх төлөвлөгөөг 24,5 хувиар тасалжээ.

Мал хашаажуулах талаар Угтаалын САА, Эрдэнэсант, Баянцагаан, Алтанбулаг, Лүн сумд бусдаасаа ихээхэн хоцрогдож байна.

Мөн нэгэнт хүч хөрөнгө зарцуулж гаргасан хашаа худгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй байна.

Одоогийн байдлаар аймгийн хэмжээгээр бүх билчээрийн 51 хувь нь өрөмдмөл ба уурхайн худгийн усаар, 26 хувь нь гол горхи, нуурын усаар хангагдаж буй тооцоотой боловч тал хээрийн сумдын билчээр өвлийн улиралд усан хангамж дутагдалтай байна.

Лүн, Баянцогт, Угтаал, Архуст сумдын билчээрийн 41-50 хувь шахам нь усаар хангагдаж чадаагүй байна.

Мөн олонхи мэргэжилтнүүдээс мал аж ахуйд мэргэжлийн ба зохион байгуулалтын удирдлага туслалцааг хангалтгүй үзүүлж байна.

Мал үржлийн ажлыг сайжруулахад мал аж ахуйн мэргэжилтнүүдийн идэвхи санаачлагыг өрнүүлэн, үржлийн ферм суурьудыг бэхжүүлж, шилэн сонголт үржүүлгийн чанарыг сайжруулах, ялангуяа нутгийн малын шилмэл хэсгүүдийг байгуулан, шинээр тавих хээлтүүлэгчийг зөв сонгон авч байвал зохино.

Мөн мал сүргийг эрүүлжүүлэх талаар аймгийн мал эмнэлгийн тасгаас явуулах мэргэжлийн удирдлага туслалцааг эрс сайжруулж, зун намрын улиралд мал олноор үхүүлдэг цусан халдварт, дотрын хордлого өвчнөөс сэргийлэх ажлыг сайн зохиох хэрэгтэй байна.

Аймгийн дунджаар 1967 онд үнээ дутмаас 569 л сүү саасан нь 1965 оныхоос 17 хувиар, хонь бүрээс авсан уртын ноос 27 гр-аар нэмэгдсэн байна.

Малын ашиг шим ашиглах талаар дутагдал их байна. Аймгийн дүнгээр ноолуур, ямаа, тэмээний ноос, бодын хялгас, хөөвөр зэрэг нэгж малаас авсан ноосны хэмжээ буурч, ялангуяа нэгдлүүдийн дунджаар үнээ, гүү дутмаас саах сүүний хэмжээнд олигтой ахиц гараагүй байна.

Үнээ бүрээс сүү сааль ашиглах талаар Баянцагаан, Баян, Өнжүүл зэрэг сумд ихээхэн хоцрогдож байна.

Мал таргалуулах, төл бойжуулах, ашиг шим авах талаар дэргэдээ юм уу дотроо гарч байгаа туршлагыг судалж бусдад дэлгэрүүлэх ажлыг муу зохиож байна.

Тэргүүн туршлагыг нэвтрүүлэх ажлыг сайжруулах талаар МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооноос саяхан гаргасан тогтоолыг биелүүлэх талаар намын нийт байгууллага тодорхой төлөвлөгөө зохиож биетэй ажилд орох хэрэгтэй байна.

Цаашид ХАА-н нэгдэл, САА бүрийг хадлангийн механикжуулсан бригадтай болгох, бог малын төлийн 70-80 хувийг хөрвийн аргаар бойжуулах, Дундговь аймгийн туршлагаар худгийг механикжуулж дулаалах, туранхай малыг цитратчилсан цусаар тарих, хиймэл сүү бэлтгэх, гидрофоны аргаар ногоон тэжээл тарьж хэрэглэх зэрэг туршлагуудыг аймгийн хэмжээгээр заавал нэвтрүүлэх, мөн үр тариа хадлангийн талаар Жаргалантад, үнээний сүү саамын талаар Гачууртад, төмс хүнсний ногооны талаар Борнуурын САА-г тус тус туршлага сургуулийн бааз болгон явуулах нь зүйтэй гэж үзэж байна. ХАА-н нэгдлүүдийн үйл ажиллагааны чанарын үзүүлэлтэд тодорхой өөрчлөлт гарч чадаагүй байна.

Тус аймгийн ХАА-н нэгдлийн эдийн засгийн үзүүлэлтийг байнга дээшлүүлж, аж ахуйг эрчимжүүлэх үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх талаар нэгдлийн зөвлөлүүд, тэдгээрийн дэргэдэх намын байгууллагууд онцгой анхаарч нэгдэлч олны бүтээлч идэвхи санаачлагыг өрнүүлэн аж ахуй, санхүүгийн нөөц боломцоог шавхан дайчлах ёстой.

Нэгдэл, САА-нуудад ердийн хөсгийг дотоодын тээвэрт ашиглах талаар зарим эхлэлт гар-

*(Үргэлжлэл нь 2 дугаар нүүрт)*

# нөхөр Ш. Агваансодовын тавьсан илтгэлийн үргэлжлэл

*(Үргэлжлэл)*

лаа. Баян, Сэргэлэн, Баянзүрх, Баянбараат, Заамар сумдад ердийн хөсгийн бригад байгуулагдаж дотоодын зонхилох тээврийг ердийн хөсгөөр гүйцэтгэдэг болж байна.

Гэвч ХАА-н зарим нэгдэл, САА-нуудад ердийн хөсөг нэмэгдүүлэх, ашиглах, морь тэмээг эдэлгээнд сургах ажил хангалтгүй хийгдэж байна.Сум бүр 100-гаас доошгүй ердийн хөсгийн бригадтай болж аж ахуйн дотоодын тээврийг ердийн хөсгөөр гүйцэтгэж байхаар заасан аймгийн намын 2 дугаар бүгд хурлын заалтыг хэрэгжүүлбэл зохино.

Одоо бид өнгөрсөн өвөл, хаврын улиралд ажиллагаа, арчилгааны муугаас хүлээсэн хохиролдоо хатуу дүгнэлт хийж, байгаа бүхий л бололцоог шавхан дайчилж БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулган, МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолуудын заалтыг хэрэгжүүлэн 1968 оны эхний хагас жилд учирсан хохирлыг нөхөх, сүүлийн хагаст гарч болох хорогдол хохирлоос урьдчилан сэргийлж, мал өсгөх төлөвлөгөөг сум, бригад, ферм, суурь бүрээр давуулан биелүүлэх эрхэм зорилт тавигдаж байна. Хөрөв төлийг бойжуулах, мал таргалуулах,малын хорогдлыг багасгах, мал хээлтүүлэг үржлийн ажлыг сайн зохион явуулах хэрэгтэй.

Мөн орон нутгийн нам, улс, ХАА-н байгууллага, мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлэх, өвөлд бэлтгэх ажлыг зун нь хийх хэрэгтэй.

Малыг саравчтай хашаа хороогоор хангах асуудлыг 1968-1969 онуудад үндсэнд нь шийдвэрлэхийн тул орон нутгийн хүчээр энэ хоёр жилд малын саравчтай хашаа 1068-ыг барьж, энгийн уурхайн худаг 278-ыг шинээр гарган улмаар усаар хангах асуудлыг 1970 онд шийдвэрлэх зорилт тавьж байна.

Мөн Жаргалантын САА-н туршлагаар нэгдэл, САА бүр хадлангийн механикжуулсан бригад гаргах, үнээ эм хонины сууриудын хэрэгцээт өвсийг өөрсдөөр нь хадуулдаг журамд энэ жилээс эхлэн орж, цаашид эдгээр сууриудыг наадах нь 3 сарын хэрэглэгдэх төрөл бүрийн тэжээлийн нөөцтэй болгох, малын тэжээлд өөрсдийн бололцоог ашиглан таана, хүмүүл, агь, тарваганы ходоод, өөх тос, адууны хомоол, хоол хүнсний хаягдал зэргийг малчид, бригад сууриудад нөөцлөн бэлтгүүлэх САА, МААМС бүх үр тарианы сүрлийн 50 хувийг боож бусдыг хурааж тэжээлд бэлтгэвэл зохино.

Аймгийн хэмжээгээр тэмээ, адуун сүрэг өсөхгүй байгаад зохих дүгнэлт хийж аймгийн нам, улс, ялангуяа хөдөө аж ахуйн байгууллага ойрын үест биетэй арга хэмжээг даруй авч явуулах шаардлагатай байна.

Тус аймаг 1968 оны 5 дугаар сарын эцсээр тоологдсон том малыг төл оролцуулахгүйгээр 25 хувиар өсгөж оны эцэст 1 сая 286,8 мянган малтай болсон байх үүний дотор ашиг шимийг голлох үхэр сүргийг 2,2 хувиар, хонийг 1,9 хувиар өсгөх болно.

Энэ төлөвлөгөө гагцхүү малын зүй бусын хорогдлыг дээд хэмжээгээр багасгаж арвилан хэмнэлтийг тууштай нэвтрүүлсэнээр шийдвэрлэгдэх ёстой.

Үүний хамт хорогдсон малын хэмжээгээр улс нийгэмд учирсан хохирлыг нийгмийн материаллаг үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний бусад зүйлээр заавал нөхөх явдал манай аймаг, сумдын нам, улс, ХАА-н байгууллагын эрхэм зорилт мөн.

Нөөц бололцоо хаягдал ашиглах ажлыг нийт ард түмний хэрэг болгон өрнүүлэх хэрэгтэй.

Мал өсгөхийн баттай үндэс бол сүргийн доторхи хээлтэгч малын эзлэх хувийн жинг зөв тогтоох явдал юм.

Түүнчлэн хээлтүүлэгчийн тохироог зөв тогтоохын тул аймгийн хэмжээгээр нэг азраганд 8 гүү оногдож, зөвхөн азраганаас бусад хээлтүүлэгч дутагдаж байгааг 1969-70 онуудад гүйцээн нөхөж тавих хэрэгтэй.

Мал өсгөх ажилд зүй бусын хорогдлыг багасгахын хамтаар цагаан идээг өргөн хэрэглэх замаар идэшинд ашиглагдаж байгаа олон тооны малыг хэмнэх хэрэгтэй байна.

1967 онд тариалангийн нийт талбай өнгөрсөн оныхоос 3,8 хувиар өсч 154000 га-д хүрэв.

1967 онд 1966 оныхоос үр тарианы ургац 57,8 хувиар, аймгийн дүнгээр 1,1 мянган тонн улаан буудайг төлөвлөгөөнөөс давуулж улсдаа тушаасны дотор Жаргалант, Угтаалын САА-нууд өндөр амжилт үзүүлжээ.

САА, МААМС-уудад хөрс боловсруулах агротехник, хаврын тариалалт, намрын хураалтын ажлын бэлтгэл зохион байгуулалт дээшилж байна.

Жаргалант, Батсүмбэр, Борнуурын САА-нууд төмс тариалалт, арчилгаа, хураалтын ажлын нилээд хэсгийг механикжуулж, Борнуурын САА хүнсний ногоо тарих, арчилах ажиллагааг механикжуулсан нь сайхан эхлэлт болов.

Гэвч САА, МААМС-уудын эрхэлж байгаа газар тариалангийн үйл ажиллагаанд хөрс боловсруулах агротехникийн арга ажиллагааг зөрчих, тарихад тохирохгүй үр суулгах, тариалах болон ургац хураах ажлыг удаашруулах, уринш цэвдэгш хагалах төлөвлөгөөг тасалдуулах, ХАА-н техникийг хангалтгүй ашиглах зэрэг дутагдал бүрэн арилаагүй байна.

Мөн машин техникийг хайр гамгүй эдэлж хугацаанаас нь өмнө эвдэж жагсаалаас гаргах, ашиглалт хадгалалт хамгаалалт муу зэрэг дутагдал САА, нэгдэл, МААМС-уудад үргэлжилсээр байна. Цаашид газар тариалангийн төлөвлөгөөг нэр төрөл дээр нь биелүүлж, орон нутгийн байгаль цаг уурын нөхцөлд нийцүүлэн хөрс боловсруулах ба тариалах арга техникийг улам сайжруулах замаар үр тариа, төмс хүнсний ногооны ургацыг эрс нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

САА, нэгдлүүд сайн чанарын сортын үрээр хэрэгцээгээ хангаж, үрийн баттай фондтой байхын тул үрийн бригад салбарыг бэхжүүлэх хэрэгтэй. Уринш, цэвдэгш хагалах төлөвлөгөөг заавал биелүүлэх, хаврын тариалалт, намрын хураалтын хугацааг аль болохоор богиносгоход ХАА-н байгууллага, инженер техникийн ажилтны хүч авъяасыг дайчлах талаар намын байгууллага тодорхой ажиллах хэрэгтэй.

Тайлангийн хугацаанд аймгийн Үйлдвэрийн холбоо, Тээвэр, Худалдааны байгууллагууд өмнөө тавигдсан зорилтыг биелүүлж ирлээ.

Аймгийн Үйлдвэр хоршооллын үйлдвэрүүд, Замын анги, Сонины үйлдвэр үйлдвэрийнхээ төлөвлөгөөг жил дараалан биелүүлжээ.

Аймгийн Барилга контор энэ 2 жилд нийтдээ 4 сая төгрөгийн барилга барьж ашиглалтанд оруулав.

Хүнсний үйлдвэр шингэн сүүгээр ээдэмцэр шинээр үйлдвэрлэж 173800 төгрөгийн ээдэмцэр улсад тушаажээ.

Керамакийн үйлдвэр шинээр байгуулагдаж, жилдээ 46000 төгрөгийн бүтээгдэхүүн гаргадаг болов. Гэвч зарим үйлдвэрийн газрууд үйлдвэрийнхээ төлөвлөгөөг үнийн дүнгээр биелүүлэхийг хичээж, нэр төрөл ард түмний хэрэгцээт шаардлагыг үл харгалзах материаллаг нөөц машин төхөөрөмжийг аж ахуйч бишээр эдлэх, ажилчдын нилээд хэсгийн мэргэжил дадлага хангалтгүй зэрэг дутагдал оршиж байна.

Мөн орон нутаг, байгалийн баялаг таана, хүмүүл, жимс, мөөг зэргийг өргөн ашиглаж хөдөлмөрчдийн өргөн хэрэгцээнд нийлүүлэх ажил удаан хийгдэж байна.

Үйлдвэр хоршооллын үйлдвэрүүд ард түмний гэр ахуйн өргөн хэрэгцээт мод, төмөр эдлэл, гутал, хүүхдийн хувцас зэрэг бүтээгдэхүүний төлөвлөгөөг тасалдуулдаг байна.

Хүнсний болон үйлдвэр хоршооллын бүтээгдэхүүний нилээд хэсгийн чанар үзэмж хийц нь өсөн нэмэгдэж байгаа шаардлагын хэмжээг хангаж чадахгүй байна.

Барилгад талбайн хөдөлмөрийг муу зохион байгуулж, барилгын механизмын хүч чадлыг хангалтгүй ашиглаж, материалын зарцуулалтад арвилан хэмнэх журмыг бүрэн нэвтрүүлж чадаагүй зэргээс барилгын өртөг өндөржиж батлагдсан төсвийг хэтрүүлдэг байна.

Цаашид үйлдвэрийн газруудад үйлдвэрийн техник, технологийг бүрэн эзэмшүүлж, үйлдвэрлэлийн үндсэн болон эргэлтийн фондын ашиглалтыг сайжруулах хөдөлмөрийн бүтээмж, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлж өөрийн өртгийг хямдруулах төлөвлөгөөг нэр төрөл бүр дээр нь биелүүлэх, арвилан хэмнэх журмыг бүрэн сахиулахад намын байгууллагын гол анхаарал төвлөрөх хэрэгтэй.

Тээвэр, холбооны байгууллагуудын материал техникийн бааз бэхжиж хүн тээвэрлэлт, телефон яриа, цахилгаан мэдээний төлөвлөгөөнүүдийг биелүүлжээ.

Гэвч Харилцаа холбооны системд ард түмнийг холбоо харилцаагаар хөнгөн шуурхай үйлчлэх зорилтоо хангалтгүй биелүүлж байна.

Тээвэр холбооны байгууллагууд төлөвлөгөөт даалгаврыг биелүүлэхийн зэрэгцээгээр хөдөлмөрчдийг үйлчлэх үйлчилгээг сайжруулж, тээвэр холбооны хэрэгслэлийг дээд зэргээр ашиглан, машин техникийн сул зогсолт, хоосон-гүйлтийг багасгах, засварын ажлын чанарыг сайжруулах хэрэгтэй байна.

Худалдаа бэлтгэлийн байгууллагууд хөдөлмөрчдийг бараа, нийтийн хоол, номоор үйлчлэх хэмжээ нэмэгдэж улсын бэлтгэлийн ихэнх зүйлийн төлөвлөгөөг биелүүлж ирэв.

Гэвч худалдаа бэлтгэлийн байгууллагууд бэлтгэлийн төлөвлөгөөг голлон хөөцөлдөөд хөдөлмөрчдийг худалдаа, нийтийн хоолоор соёлч боловсон, хөнгөн гавшгай үйлчлэх үйлчилгээнд хангалтгүй хандаж байна.

Малын ноос, сүү, бусад бүтээгдэхүүний ашиглалтыг сайжруулан чанарыг дээшлүүлэхэд худалдаа бэлтгэл, ХАА-н байгууллагын ажиллагаа чиглэх ёстой.

Хүн амыг бараа товараар үйлчлэх үйлчилгээг өөрчлөн сайжруулах талаар худалдааны байгууллага онцгой анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Өнгөрөгч 2 жилд тус аймгийн хэмжээгээр ажилчин албан хаагчдын цалингийн фонд 4,6 хувь өсч хүн амын бодит орлого 7,4 хувиар нэмэгджээ. 1966-67 онд аймгийн бага дунд сургуульд суралцагчдын тоо 14,2 хувиар, насанд хүрэгчдийн оройн сургуульд суралцагчдын тоо 11,7 хувиар тус тус өслөө.

Тэрчлэн сумдад соёл урлагийн үзлэг зохиогдож хэд хэдэн сумд соёл урлагийн 3 хоногуудыг аймгийн төвд явуулсан байна.

Аймгийн Соёлын ордны дэргэдэх сайн дурын драмын дугуйлан ардын театр болтлоо өсч цол мандатаа авлаа.

Аймгийн хэмжээгээр соёлжилтын 2 жилийн зохистой ажил зохиож ажилласнаар айл өрхийн соёлжилт дээшилжээ.

Гэвч бага дунд сургуулиудын сурагчдын сурлага, ялангуяа сахилга бат жигд сайжирч чадаагүй, зарим сумдын сургуулийн хичээлийн ба дотуур байрны хүрэлцээ, тохижилт хангалтгүй сумдын клубуудын ажил тогтмолжоогүй,урлаг уран сайхны чанар муу байна.

Эмнэлгийн байгууллагууд өвчнөөс урьдчилан сэргийлэх ариун цэвэр эмнэлэг гэгээрлийн ажлыг эмчилгээ, үйлчилгээний ажилтай хослож чадаагүй, зарим сумдын салбарын эрхлэгч, эмч нарын ажлын хариуцлага, сахилга бат тогтвор суурьшил хангалтгүй байна.

Биеийн тамир спортын байгууллагын ажил нийтийн хүртээл болж чадаагүй зөвхөн нэр бүхий хэдэн тооны тамирчидтай ажиллах төдийгөөр ажлаа хязгаарлаж байна.

Соёл гэгээрэл,эмнэлэг,спортын байгууллагууд дээрхи дутагдалд дүгнэлт хийж орон нутгийн салбар байгууллагуудын ажлыг шалгаж зааварлах туслах ажлаа сайжруулбал зохино.

### ХОЁР. Намын үзэл суртал улс төр, олон түмний ажлын үр нөлөөг дээшлүүлэх талаар зохиосон ажил цаашид тавих зорилт

Аймгийн Намын Хороо хөдөлмөрчдийн дунд зохиох намын үзэл суртал, улс төр, олон түмний ажлаа МАХН-ын 15 дугаар их хурал,намын шинэ программын заалтын үндсэн дээр хөдөлмөрчдөд ертөнцийг үзэх Марксист-Ленинист шинжлэх ухааны үзэл, эх оронч интернационалч үзлийг эзэмшүүлэх, өөрийн орны социалист бүтээн байгуулалтад ухамсартай оролцох санаачлага идэвхий нь өрнүүлэхэд чиглүүлэн зохиож ирлээ.

Үзэл суртал,улс төр,олон түмний ажлыг нийгмийн тодорхой судалгааны үндсэн дээр явуулах эхлэлт бий болж байгаагийн үрээр уул ажлын агуулга сайжирч хэлбэр нь улам баяжлаа.

Гарын авлага материалуудыг боловсруулан гаргаж, үзүүлэн таниулахыг өргөжүүлэн, үйлдвэрлэлийн үндсэн нэгж тасаг бригад,ферм,цех, суурь аравтуудад зохиогдох сургууль, хүмүүжлийн ажлын эрч далайцыг нэмэгдүүллээ.

1966-1967 оны намын гэгээрлийн хичээлийн жилд дугуйлан, онолын семинарын сонсогчдын 60-70 гаруй хувь нь онц ба сайн дүн үзүүлсэн бол 1967-1968 оны хичээлийн жилд төв хөдөөд улс төрийн анхан, дунд шатны сургууль,онолын семинарт 1500 гаруй хүн суралцаж жилийн эцсийн шалгалтаар 100 хувийн сурлагын дүн үзүүлсний

*(Үргэлжлэл нь 3 дугаар нүүрт)*